

# ӨНДӨРХААН ХК

2022 оны 4 сарын 25-ны өдөр

№22/01

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг, 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өндөрхаан” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэснийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГБАДРАХ

# ӨНДӨРХААН ХК

2022 оны 4 сарын 25-ны өдөр

№22/02

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн бүртгэлтэй үнэт цаасны арилжаа эрхлэх  
байгууллагыг өөрчлөх тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь хэсэг, 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өндөрхаан” ХК-ийн Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-тай байгуулсан Бүртгэлийн гэрээг цуцалж, Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК-тай Бүртгэлийн гэрээ байгуулах, бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага өөрчлөхийг зөвшөөрсүгэй.
2. Бүртгэлийн гэрээг шинэчлэн байгуулах, бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагыг өөрчлөхтэй холбогдсон нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, түүнд заагдсан ажлыг хууль, журамд заасны дагуу зохион байгуулж, явуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГБАДРАХ